



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 5/02

Ховд

С.Ганзоригийг ажилд томилох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Дуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 05/14148 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Сэнгээгийн Ганзоригийг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн Дуут сумын Засаг даргаар томилсугай.

2.С.Ганзоригт Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 943539 төгрөг /Есөн зуун дөчин гурван мянга таван зуун гучин есөн/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Дуут сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг С.Ганзоригт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/02 Ch
02 0005